

ЭРДЭНЭ РЕСУРС ХАР МОРЬ АЛТНЫ ТӨСЛИЙН ХАЙГУУЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛЖ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭН СУДЛАХ ӨРӨМДЛӨГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Хэвлэлийн мэдээ
Нова Скошиа муж, Халифакс хот
2021.06.15

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Хар Морь талбайн 2021 оны 2-р улиралд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцуулж байна. Хар Морь нь газрын дөт гүнд илрүүлсэн алтны шинэ нээлт бөгөөд Компанийн тэргүүлэх төсөл болох Баян Хөндий төслөөс хойд зүгт 3.5 км зайд оршдог. 2021 оны 2-р улиралд нийт 3,757 метрийн 37 цооног өрөмдсөнөөс 2,610 метрийн 27 цооногийн өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг энэ мэдээгээр танилцуулж байна. Мөн Хар Морь алтны нээлтийн талбайд 3,000 метрийн өргөтгөсөн өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлснийг дуулгахад таатай байна.

Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Бидний гүйцэтгэсэн хайгуулын ажил, түүнчлэн өнөөдөр танилцуулж буй үр дүнгүүд нь Хар Морь шинэ нээлтийн цар хүрээг баталгаажуулсаар байна.” “Сүүлийн хэдэн сарын хугацаанд бид Хар Морь талбайн Дэл бүсийн урд хэсэгт өндөр агуулга бүхий, газрын дөт гүнд исэлдсэн алтны бүс болон энэ бүсийн хойд трендийн дагуу бага агуулга бүхий өргөн бүсүүд, мөн зүүн хойд хэсэгт огтлолцох структурын дагуу өндөр агуулга бүхий алтны хэд хэдэн бүсийг огтлохын зэрэгцээ энэхүү том зорилтот талбайн геологи болон бүтцийн шинж чанарын талаарх ойлголтыг баталгаажуулсан.”

“Одоо эхлүүлж буй 3,000 метрийн өрөмдлөгийн өргөтгөсөн хөтөлбөрийг төлөвлөх зорилгоор эдгээр үр дүнг ашигласан.” “Өрөмдлөгийн өргөтгөсөн хөтөлбөр нь дараах хоёр зорилготой: Баян Хөндий Алтны төсөлд нэгтгэх боломжтой Хар Морь талбайн Дэл бүсийн газрын дөт гүнд орших нөөцийн хүрээг тодорхойлох болон илүү өргөн хүрээнд буюу 12 километр квадрат талбайн хэтийн төлөв бүхий зорилтот бүсүүдэд туршилт хийх. Энэхүү зорилтот талбайг бүрэн ойлгох эхний шатандаа байгаа бөгөөд ирээдүйд гүйцэтгэх өрөмдлөгийн хөтөлбөрөөр бид илүү гүн болон структурын коридорт чиглэсэн өрөмдлөг хийхээр төлөвлөж байна.

Онцлох мэдээлэл¹ (План зурагтай хавсралтаас танилцана уу):

- Хар Морь талбайн Дэл бүсийн урд зүгт гүйцэтгэсэн өрөмдлөгийн ажлаар өргөн, газрын дөт гүнд (100 метрийн гүнд), бага агуулга бүхий алтны бүсүүдийг баталгаажууллаа:
 - AAD-89, AAD-95 болон AAD-98 цооногуудын огтлолцолд хамгийн өндөр хувирал болон эрдэсжилттэй бүсүүд илэрсэн ба алт агуулсан хэд хэдэн бүсийг огтолсон.
 - Эдгээр цооног нь Хойд- Урд бүсийн 300 метр дотор байрладаг, AAD-61 (130 метр 0.5 г / т алт)-аар шалгасан нам соронзон шинж чанарыг тойрон хүрээлсэн байдаг.
 - Энэхүү бүсэд өрөмдлөг гүйцэтгэх бүрд алтны шинж чанар болон хувирлын бүсийн зузаан нэмэгдэж бөгөөд цаашид энэхүү бүсэд илүү гүн өрөмдлөг гүйцэтгэх шаардлагатайг харуулсан.
- AAD-81 цооногоос урд зүгт 200 метр (39 метр 2.7 г/т алт) зайд алт болон дайвар элементүүдтэй аномаль нь 60-аас 130 метрийн гүнд нэмэгдэж, шинэ зорилтот гүн өрөмдлөгийн бүсийг тодорхойлж өгсөн.
- Туршилтын үр дүнд зүүн хойд структурын огтлолцолд алтны эрдэсжилттэйг харуулж, 7 метрийн өргөнтэй алтны эрдэсжсэн интервал дотор AAD-110 цооногт 7.3 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон.
- Хар Морь талбайд 3,000 метрийн өргөтгөсөн өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлээ, өрөмдлөгийн ажил нь:
 - Ойрын хугацаанд Баян Хөндий Алтны төслийн төлөвлөгөөнд нэгтгэх боломжтой газрын дөт гүнд орших нөөцийн хүрээг тодорхойлох, ба
 - Хар Морь талбайн Дэл бүсэд илүү гүний болон захын бүсийн зорилтуудыг судлах.

Хар Морь Хайгуулын Хөтөлбөр

Өнөөдрийн хэвлэлийн мэдээнд дурдсан өрөмдлөгийн хөтөлбөрт Хар Морь талбайн Дэл бүсийн хэтийн төлөвийн талбайн хойд хэсэг (ойролцоогоор 750м Хойд-Урд) багтсан бөгөөд 27 цооногийн 15 нь газрын дөт гүний (100 метр доторх) исэлдсэн алтны бүсийг туршиж үзнэ. Түүнчлэн, хоорондоо өргөн зайтай зургаан цооногоор өндөр агуулга бүхий (AAD-58 болон 81) Хар Морь алтны нээлтийн талбай ба Баян Хөндий алтны ордын хооронд өмнөд хэсгийн структур үргэлжилж буй эсэхийг туршиж үзнэ. Үлдсэн зургаан цооног нь зорилтот хэсэгт, өргөн хүрээнд зүүн хойд структурууд нь параллель буюу огтлолцлыг туршиж үзсэн.

Хар Морь талбайн Дэл бүсийн хойд хэсгээс гарсан үр дүн нь газрын дөт гүнд, бага агуулга бүхий, исэлдсэн алтны эрдэсжилтийн үргэлжлэлийг баталгаажуулж байна, структурын урд хэсгийн үргэлжлэлийн дагуу болон зүүн бүсэд байрших зүүн хойд чиглэсэн структурын трендийн дагуу өмнө нь тодорхойлж байсан өндөр агуулга бүхий бүсүүдийг бататгаж байна. Энэхүү бүсэд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хүрээнд

¹ Хэвлэлийн мэдээнд тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропийг тодорхойлох боломжтой.

хэд хэдэн газарт хос цооног өрөмдсөн ба илүү гүн өрөмдсөн цооногт алтны шинж чанар болон хувирлын бүсийн зузаан нэмэгдэж байсан ба цаашид энэхүү бүсэд гүний өрөмдлөг буюу 100 метрээс дээш гүнд өрөмдлөг гүйцэтгэх шаардлагатайг харуулсан. Түүнчлэн, зорилтот структураас баруун зүгт алт агуулсан бүстэй хэд хэдэн цооног огтлолцсон ба цооногийн ёроолын ойролцоо 0.5 г/т - 1.5 г/т алт агуулсан 1-2 метрийн интервал огтолсон.

Хүснэгт 1 – Хар Морь 2021 оны 2-р улиралд гүйцэтгэсэн Хар Морь талбайн Дэл бүс дэх өрөмдлөгийн ажлын онцлох мэдээлэл (түүвэрлэсэн интервалууд)

Цооног	Эхлэл (м)	Төгсгөл (м)	Интервал ⁽¹⁾	Алт (г/т)
AAD-89	56	74	18	0.73
Түүнд	63	68	5	1.72
AAD-90	63	73	10	0.83
AAD-93	23	43	20	0.46
AAD-95	36	64	28	0.46
Ба	70	74	4	0.77
Ба	142	144	2	1.17
AAD-96	42	48	6	0.54
AAD-98	24	28	4	1.12
Ба	73	84	11	0.57
Ба	122	124	2	0.84
AAD-99	21	32	11	0.42
Ба	60	65	5	0.65
Ба	110	125	15	0.59

¹ Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.

Өндөр агуулга бүхий бүсийн өмнөд хэсгийн өрөмдлөг AAD-81 (2.7 г/тн алтны агуулга бүхий 39 м) ба AAD-58 (6 г/тн алтны агуулга бүхий 45 м) цооногуудыг огтолсон ба 100 метрийн зайд хоёр зорилтот бүсэд туршилт хийсэн. AAD-81 цооногоос урд зүгт 100 метрийн зайд, хоёр томоохон гажилтын тайлал бүхий огтлолцолд хүчтэй төмрийн исэлдлийн филикийн хувирал AAD-84 цооногт ажиглагдсан, өргөн бүсэд бага агуулгатай хэдий ч анамоль алт ба дайвар элементийн хэмжээ, 40 метрийн гүнд хийсэн туршилтын бүсэд ихээр ажиглагдсан. Цаашилбал, урд чиглэлд 100 метрийн алслалд алт болон дайвар элементийн анамоль AAD-101 цооногт ихээр нэмэгдсэн ба цооногийн 60-130 метрт эрчимтэй судалжилт, исэл ба шаврын хувирал илэрсэн нь шинээр илүү гүн өрөмдөх шаардлагатайг харуулсан. Үндсэн структурын дагуу хувирал ба эрдэсжилтийн тасралыг шалгах 250 – 300 метр гүний цооногуудыг үргэлжлүүлэн урд зүгт өрөмдөж дууссан. Гидротермаль хувирлын шинж тэмдэг ажиглагдсан хэдий ч агуулагч чулуулагт нь алт хуримтлагдах боломж Хар Морь талбайн Дэл бүсээс бага болох нь ажиглагдсан. Гэхдээ энэ бүсийн умард зүгт нэмэлт хайгуул хийх шаардлагатай.

Хар Морь талбайн Дэл бүсийн зүүн зүгт ойролцоогоор 700 метрт байрших талбайд AAD-110 цооногийн Зүүн Хойд структурын зүүн чиглэлийн тасралтыг шалгасан. Энэ нь AAD-81 цооногийн талбай дахь Хар морь структуртай огтлолцдог. Газрын дөт гүн болон цооногийн 100 метрийн гүнд алт агуулах шинэ бүс илэрсэн.

Хүснэгт 2 – Хар Морь талбайн Дэл бүсийн урд болон зүүн чиглэсэн өрөмдлөгийн ажлын онцлох мэдээлэл (түүвэрлэсэн интервалууд)

Цооног	Эхлэл (м)	Төгсгөл (м)	Интервал ⁽¹⁾	Алт (г/т)
AAD-101	81	84	3	0.39
Ба	107	113	6	0.32
AAD-110	5	7	2	0.34
Ба	94	101	7	1.46
Түүнд	100	101	1	7.34

2021 оны 6 дугаар сард хийгдэх Хар Морь хайгуулын хөтөлбөрийн зорилго

Энэ долоо хоногт эхлүүлсэн өрөмдлөгийн өргөтгөсөн хөтөлбөр нь дараах хоёр зорилготой: Баян Хөндий Алтны төсөлд нэгтгэх боломжтой Хар Морь талбайн Дэл бүсийн газрын дөт гүнд орших нөөцийн хүрээг тодорхойлох болон илүү өргөн хүрээнд буюу 12 километр квадрат хэмжээтэй талбайд хэтийн төлөв бүхий зорилтот бүсүүдэд туршилт хийх болно.

AAD-57 болон AAD-58 цооногуудын өндөр агуулга бүхий бүсүүдийн огтолцлыг тойрсон хэсгүүдэд ойролцоогоор 1,500 уртааш метр тодорхойлох өрөмдлөг төлөвлөсөн. Баян Хөндийн Алтны төслийн баяжуулах үйлдвэрт ашиглахаар сонгосон уламжлалт нүүрстэй уусгах технологид тохирох, газрын дөт гүнд, алтны эрдэсжилтийн өндөр агуулга бүхий, исэлдсэн хүдрийг тодорхойлох 30 метрийн хоорондын зайтай, 100 метрийн гүн цооногуудыг өрөмдөх ажлыг хийж гүйцэтгэнэ.

Өргөжүүлэх өрөмдлөг хэтийн төлөв бүхий Хар Морь талбайн Дэл бүсийн хайгуулын талбай дотор эрдэсжилтийн үргэлжлэх гүнийг шалгах бөгөөд мөн Хар Морь талбайн Дэл бүстэй үүсэл гарлын хувьд ижил төстэй структур, геофизикийн шинж тэмдэг бүхий зэргэлдээ хэсгүүдэд анхаарал төвлөрүүлнэ.

Түүнчлэн илүү гүний хайгуулд дэмжлэг үзүүлэх зорилгоор геофизикийн гүний судалгааны “CSAMT” арга ба нарийвчилсан диполь-диполь туйлшралын (“Dp-Dp IP”) аргуудыг ашиглан геофизикийн судалгааг Хар морь хэтийн төлөв бүхий талбайн 4 км² хэсэгт гүйцэтгэнэ. Энэ судалгаагаар эпипермаль үүсэлтэй судлын системүүдтэй холбоотой цахиуржилт болон шаврын хувирлыг илэрхийлэгч чулуулгийн цахилгаан эсэргүүцэх, дамжуулах чадварын бүсүүдийг тодорхойлно. Энэ хөтөлбөрийн үр дүнгээр хайгуулын энэхүү томоохон зорилтот талбайд цаашид өрөмдөх цооногуудын гүнийг тодорхойлно.

Хар Морь

Компани нь 2019 оны 8 дугаар сард Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн урьд нь судалгаа хийж байгаагүй хэсэгт Хар Морь хэтийн төлөв бүхий талбайг Баян Хөндий ордоос зүүн хойш 3.5 км газарт нээн илрүүлсэн. 2019 оны эцсээр гадаргуун хайгуулын ажил гүйцэтгэсэн, үүнд геологийн зураглал, геохимийн судалгааг (чулуун болон хөрсний дээжлэлт) хийсэн бөгөөд хэд хэдэн чулуун дээжид буюу сиенитийн порфирийг зүссэн комб кварц-адуларын судалд 5 г/т-оос 87.8 г/т хүртэлх алтны агуулга илэрсэн. 2020 оны 6 дугаар сард Компани нь Хар Морь талбайд үргэлжлүүлэн суваг малталт хийсэн ба сорьцлолтын үр дүнд 8.8 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал огтлолцол, үүнд 50.8 г/т алтны агуулгатай 1 метрийн интервал огтлолцол болон 14 г/т алтны алтны агуулга бүхий 4 метрийн интервал огтлолцол илрүүлсэн. Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд анхны буюу 25 цооногоос бүрдэх нийт 4660 метрийн өрөмдлөгийн ажлыг 2020 оны хоёрдугаар хагаст хийж дуусгасан. Хайгуулын хөтөлбөрийн үр дүнд Хойд-Урд тренд, 1.4 км урт үргэлжилсэн эрдэсжилтийн структурыг тодорхойлсон, үүнийг Хар Морь талбайн Дэл бүс хэтийн төлөв бүхий талбай гэж нэрлэсэн ба Хар Морь талбай нь Баян Хөндий алтны ордын нээлтээс хойш бидний илрүүлсэн хамгийн чухал эрдэсжсэн бүс болсон.

2020 оны 8-р сард анхны өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэснээс хойш Компани нь Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд нийт 71 цооног буюу 10,342 метр өрөмдлөг хийж, ойролцоогоор 4.6 км (Зүүн-Баруун) 2.6 км (Хойд-Урд) талбайг хамарсан. Өрөмдлөгийн цооногийн босоо гүн нь 35-аас 292 метрийн хооронд ба дунджаар 112 метр байв. Огтлолцлуудын онцлох мэдээлэл:

- 194 метрээс эхлэн 1.74 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал багтаасан 1.18 г/т алтны агуулга бүхий 48 метрийн интервал (AAD-57)
- 10 метрээс эхлэн 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон нь 27.07 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал (AAD-58)
- AAD-58 цооногоос хойд зүгт 500 метр газар байршилд 10 метрээс эхлэн 0.53 г/т алтны агуулга бүхий 130 метрийн интервал (AAD-61).
- 53 метрээс эхлэн 1.31 г/т алтны агуулга бүхий 14 метрийн интервал болон 112 метрээс эхлэн 1.74 г/т алтны агуулга бүхий 20 метрийн интервал (AAD-66)
- 4 метрээс эхлэн 2.65 г/т алтны агуулга бүхий 35 метрийн интервал, үүнд 5.10 г/т алтны агуулга бүхий 12 метр интервал огтолсон (AAD-81)

2021 оны эхний улиралд, Эрдэнэ Ресурс Хар Морь талбайд 1,900 метрийн хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн, үүний дараагаар нэмж 3,575 метрийн өрөмдлөгийг 2021 оны 4-р сард гүйцэтгэв, энэхүү өрөмдлөгийн эцсийн үр дүнг өнөөдөр танилцуулж байна. Өрөмдлөгийн огтлолцлын онцлох мэдээллийн хүснэгтийг энэхүү хэвлэлийн мэдээллийн Хүснэгт 3-т оруулсан.

Үүний зэрэгцээ, цаашид гүйцэтгэх хайгуулын хөтөлбөрт багтах өрөмдлөгийн чиглэлүүдийг тодорхойлох үүднээс, Хар Морь талбайн үнэлгээ болон тайллын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн, үүнд геофизикийн загварчлал, шавар эрдсийн шинжилгээ, петрограф, эрдэс судлал, шингэний ормын мөрийн судалгаа, 3D загварчлал багтсан болно.

Монгол Улс дахь Ковид-19 нөхцөл байдал

Эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар өдөр бүр мэдээлэл өгч, биеийн температур шалгах, эрүүл ахуйн тусгай протоколыг мөрдөх, түргэвчилсэн оношлуур ашиглах болон нэмэлт хувийн хамгаалалтын хэрэгслийг Монгол Улс дахь Компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Компани нь төслийн талбайд Ковид-19 шинжилгээг хийж гүйцэтгэх болон хайгуулын ажлын явцад эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлан сувилагч ажиллуулж байна. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр, манай баг хээрийн ажлыг тасалдуулалгүй үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Компанийн захиргааны баг нь ажлын хуваарьт зохих өөрчлөлтүүдийг оруулан, үйл ажиллагааг тасалдуулахгүй байх эрүүл ахуйн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй Эрдэнэ Ресурс болон гэрээт компанийн бүх ажилтан коронавирустэй эсрэг вакцины хоёр тунд бүрэн хамрагдсан. Эрдэнэ Ресурс болон гэрээт компанийн ажилтнууд хээрийн анги руу явахаас өмнө Ковид 19-ийн шинжилгээний сөрөг хариутай байх шаардлагатай бөгөөд кемпэд ирсний дараа ажилтнууд болон гүйцэтгэгч нарын өмнөх хариуг баталгаажуулах үүднээс хоёр дахь удаагийн түргэвчилсэн КОВИД-ийн шинжилгээг авч ажиллаж байна.

Хөндий Алтны Дүүргийн Тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц² (“Measured and Indicated Resources”)³, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй [ЭНДЭЭС](#) танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй [ЭНДЭЭС](#) танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан

² Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43- 101 техникийн тайлангаас танилцана уу.

³ Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2022 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүрдгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүрдгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологч) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмит спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд

тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

Хүснэгт 3 – Хар Морь 2021 өрөмдлөгийн онцлох мэдээлэл (0.3 г/т алтны агуулгаас дээш интервалууд)

Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал (1)	г/т алт (2)
AAD-57	52	68	16	0.58
Ба	160	180	20	0.45
Ба	194	242	48	1.18
Түүнд	202	232	30	1.74
AAD-58	10	55	45	5.97
Түүнд	32	54	22	11.98
Түүнд	36	37	1	21.18
Түүнд (3)	41	49	8	27.07
Түүнд	43	44	1	82.53
AAD-61	10	140	130	0.53
Түүнд	14	40	26	1.06
Түүнд	92	96	4	1.25
Түүнд	120	129	9	1.07
AAD-65	113	120	7	1.15
Ба	128	142	14	0.51
Ба	196	205	9	0.69
AAD-66	53	67	14	1.31
Ба	112	132	20	1.74
Ба	137	139	2	0.96
AAD-67	110	116	6	0.32
AAD-68	192	194	2	1.41
Ба	250	252	2	0.47
AAD-70	52	53	1	0.66
Ба	64	66	2	4.24
Ба	110	116	6	0.33
AAD-74	36	37	1	0.38
AAD-75	37	38	1	0.33
Ба	45	48	3	0.32
Ба	120	121 (EOH)	1	0.38
AAD-76	56	58	2	0.35
AAD-77	62	72	10	0.37
Ба	135	138	3	0.30
AAD-79	31	39	8	1.81
Түүнд	32	36	4	3.23
AAD-80	11	12	1	0.97
AAD-81	4	39	35	2.65
Түүнд	5	17	12	5.10
Түүнд	5	6	1	19.11
Түүнд	12	13	1	14.04
AAD-82	39	48	9	0.30
Ба	75	76	1	0.31
AAD-83	239	241	2	0.73
AAD-84(4)	48	52	4	0.32

Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал (1)	г/т алт (2)
AAD-87 ⁽⁴⁾	6	7	1	0.36
Ба	83	87	4	0.33
AAD-89 ⁽⁴⁾	56	74	18	0.73
Түүнд	63	68	5	1.72
Ба	87	88	1	0.41
Ба	124	125 (ЕОН)	1	0.45
AAD-90 ⁽⁴⁾	63	73	10	0.83
AAD-93 ⁽⁴⁾	17	49	32	0.35
Түүнд	23	43	20	0.46
AAD-94 ⁽⁴⁾	15	16	1	0.44
Ба	36	38	2	0.43
AAD-95 ⁽⁴⁾	21	27	6	0.30
Ба	36	64	28	0.46
Ба	70	74	4	0.77
Ба	93	95	2	0.31
Ба	104	105	1	0.39
Ба	114	121	7	0.38
Ба	142	144	2	1.17
AAD-96 ⁽⁴⁾	42	48	6	0.54
AAD-97 ⁽⁴⁾	11	13	2	0.84
AAD-98 ⁽⁴⁾	24	28	4	1.12
Ба	73	84	11	0.57
Ба	122	124	2	0.84
AAD-99 ⁽⁴⁾	21	32	11	0.42
Ба	60	65	5	0.65
Ба	110	125	15	0.59
AAD-100 ⁽⁴⁾	37	42	5	0.40
AAD-101 ⁽⁴⁾	81	84	3	0.39
Ба	107	113	6	0.32
AAD-110 ⁽⁴⁾	5	7	2	0.34
And	94	101	7	1.46
Түүнд	100	101	1	7.34

¹ Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Хар Морь талбайд эрдэсжсэн бүсийн чиглэлийг тодорхойлох хангалттай өрөмдлөг хийгдээгүй тул одоогоор бодит зузааныг тодорхойлох боломжгүй. Хайгуулын өрөмдлөгийн цооногууд нь (зөв өнцгөөр) 45-75 градусын уналтаар энгийнээс боломжит эрдэсжсэн талбайн трендийн дагуу өрөмдсөн

² Тайлагнасан интервалын агуулга нь дунджаар 1-2 метр интервалын дээжид тулгуурласан жигнэсэн дундаж агуулга болно. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

³ 1 метр интервал бүхий 8 дээжийн 7-д нь 10 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн ба 8 дахь дээжид 9.5 г/т алтны агуулга илэрсэн. Хамгийн өндөр агуулга бүхий интервал (43-44 метр) -ыг тусад нь тайлагнасан.

⁴ Шинээр тайлагнасан

ЕОН – Цооногийн төгсгөл (мэдээлсэн эрдэсжилтийн дүнгүүд нь цооногийн төгсгөл хүртэл үргэлжилсэн – эрдэсжилтийн хэмжээг бүрэн тодорхойлох үүднээс цооногт нэмэлт өрөмдлөг хийж болно)

Тэмдэглэл: Дээр дурдагдаагүй хайгуулын цооногуудад аномаль алт ба/эсвэл хавсрах элементүүд (As, Mo, Sb) огтолсон боловч 0.3 г/т алтны агуулгаас өндөр интервал огтлоогүй.

Dark Horse Prospect Location Map



Dark Horse Exploration Highlights – 2021

